

ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

О.Мөнхсайхан, Г.Цагаанбаяр, Ж.Алтансүх

Монгол Улсын хувьд Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ) бусад улсын шүүхийн зөвлөлтэй харьцуулахад илүү өргөн эрх мэдэлтэй ба шүүхийн захиргааны бараг бүх эрх мэдлийг дангаар хэрэгжүүлж эсхүл хэрэгжүүлэхэд оролцдог. ШЕЗ нь шүүх эрх мэдэлтэй холбоотой бодлого, шүүхийн менежмент, шүүхийн төсөв, шүүгчийн шалгаруулалт, шүүгчийн гүйцэтгэлийн үнэлгээ, шүүгчийн ёс зүй, сахилгатай холбоотой чиг үүрэг, түүнийг дагасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр 2012 оны Шүүхийн тухай багц хуульд заасан. Дээрх нөхцөл байдлыг харгалзан Монгол Улс дахь шүүхийн захиргааны загварын тулгамдсан асуудлыг тоймлон тодорхойлж, түүнийг шийдвэрлэх арга замыг санал болгох зорилгоор Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр бодлогын судалгаа хийж гүйцэтгэсэн юм. Уг судалгаанд үндэслэн гаргасан бодлогын Зөвлөмжийг энэхүү Бодлогын асуудлаар нийтийн хүртээл болгож байна (Судалгааны дэлгэрэнгүй тайланг www.forum.mn хаягаар орж үзнэ үү).

ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ЗАГВАРУУД

Бие даасан, хариуцлагатай шүүх эрх мэдэл төлөвшсөн улсуудад шүүхийн захиргааны гурван үндсэн загвар байдаг: Хойд Европ, Өмнөд Европ болон Хууль зүйн яамны загвар. Энэ гурван загварын эхний хоёр нь бие даасан, завсрын байгууллага болох шүүхийн зөвлөлд шүүхийн захиргааны зарим тодорхой эрх мэдэл өгдгөөрөө онцлог. Эдгээрийн алинд нь ч шүүхийн захиргааны бүх чиг үүрэг, эрх мэдлийг нэг байгууллагад төвлөрүүлдэггүй. Тухайлбал, Хойд Европ загвартай улсуудад шүүхийн зөвлөл нь зөвхөн шүүх эрх мэдэлтэй холбоотой бодлого тодорхойлох, шүүхийн менежментийг хэрэгжүүлэх, шүүхийн төсөв, санхүүгтэй холбоотой чиг үүргийг

хэрэгжүүлдэг бол тусдаа бие даасан байгууллагууд шүүгчийн шалгаруулалт болон шүүгчийн ёс зүйн асуудлыг хариуцдаг. Харин Өмнөд Европ загвар бүхий улсуудад шүүхийн зөвлөл голчлон шүүгчийн шалгаруулалт болон сахилгатай холбоотой чиг үүрэг хэрэгжүүлдэг бөгөөд хууль зүйн яам нь бодлого тодорхойлох, шүүхийн менежментийг хэрэгжүүлэх, шүүхийн төсөв, санхүүгийн асуудлыг хариуцдаг. Хууль зүйн яамны загварт ч шүүхийн захиргааны бүх чиг үүргийг төвлөрүүлдэггүй. Хууль зүйн яам шүүх эрх мэдлийн талаарх бодлого, шүүхийн менежмент, шүүхийн төсөв, шүүгчийн шалгаруулалт, шүүгчийн гүйцэтгэлийн үнэлгээ

хариуцдаг ба үүндээ янз бүрийн хэлбэрээр шүүгчдийг татан оролцуулдаг. Харин шүүгчийн ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх чиг үүрэг хэрэгжүүлдэггүй.

Шүүхийн зөвлөлтэй улсууд дотор шүүхийн бие даасан байдлын болон эрх зүйт ёсны индексээр хамгийн эхэнд жагсдаг улсуудад шүүхийн захиргааны чиг үүргийг өөр өөр бие даасан байгууллагад хуваарилж, хяналт, тэнцлийг хангасан байх бөгөөд шүүхийн зөвлөлд цөөн чиг үүргийг хариуцуулжээ (хүснэгтийг харна уу).

Дэлхийн Эдийн засгийн форумаас улс орнуудын “Даяаршлын өрсөлдөх чадварын тайлан”-г жил болгон гаргадаг. 2014 онд энэ судалгаагаар Хойд Европ



О.МӨНХСАЙХАН

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд профессор, доктор. Тэрээр улс төр, эрх зүйн онол, үндсэн хуулийн эрх зүй, хүний эрх, хуульчийн болон шүүгчийн ёс зүйн чиглэлээр судалгаа хийж, бакалавр, магистр, докторын ангиудад хичээл заадаг.



Г.ЦАГААНБАЯР

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант бөгөөд иргэний эрх зүй, өмчийн эрх зүй, үүргийн эрх зүйн чиглэлээр судалгаа хийдэг. Хуульч, өмгөөлөгчөөр ажилладаг.



Ж.АЛТАНСҮХ

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант бөгөөд нийтийн эрх зүй, улс төрийн эдийн засаг, хуулийн эдийн засагт үзүүлэх үр нөлөөний асуудлаар судалдаг. Эрчим хүчний яаманд хууль зүйн мэргэжилтнээр ажилладаг.

Шүүхийн зөвлөлийн чиг үүрэг, шүүхийн бие даасан байдал¹

Улс	Шалгаруулалт, томилгоо	Дэвшүүлэх	Сахилга	Үнэлгээ	Сургалт	Төсвийн менежмент	Шүүхийн менежмент	Мэдээллийн сан, олон нийтийн мэдээлэл	Бодлогын зөвлөгөө	Шүүхийн бие даасан байдал ²	
										байр	оноо
Дани										3	6.5
Норвеги										4	6.3
Ирланд										6	6.3
Швед										17	5.7
Эстон										19	5.7
Франц										33	5.0
Португал										44	4.5
Унгар										56	4.0
Грек										70	3.7
Итали										78	3.5
Румын										84	3.5
Боливи										94	3.3
Испани										97	3.2
Мексик										98	3.2
Турк										101	3.1
Монгол										108	2.9
Болгар										126	2.3
Аргентин										127	2.3
Словак										130	2.3

загвартай улсууд болох Дани, Норвеги, Ирландад шүүхийн бие даасан байдлаараа 6.5-6.3 оноо авч тус тус 3, 4, 6-р байрт, Швед 5.7 оноо авч 17-р байрт оржээ. Өмнөд Европын загвартай улсууд болох Франц 5.0 оноо авч 33, Португал 4.5 оноо авч 44, Грек 3.7 оноо авч 70, Итали 3.5 оноо авч 78-р байрыг тус тус эзэлжээ. Гэвч шүүхийн зөвлөлдөө шүүхийн захиргааны бараг бүх, эсвэл ихэнх чиг үүргийг төвлөрүүлсэн улсууд болох Болив 3.3 оноо авч 94, Мексик 3.2 оноо авч 98, Монгол 2.9 оноо авч 108, Аргентин 2.3 оноо авч 127-р байрт тус тус оржээ. Дани, Норвеги, Швед зэрэг Хойд Европ загвартай улсууд нь Франц, Итали, Испани зэрэг Өмнөд Европ загвартай улсуудаас илүү шүүхийн захиргааны эрх мэдлийг хуваарилдаг учраас шүүхийн бие даасан байдал, эрх зүйт ёсны шалгуураар дээгүүрт эрэмбэлэгддэг.

Шүүхийн зөвлөлд шүүхийн захиргааны эрх мэдлийг хэт төвлөрүүлэх нь уг эрх мэдлийг урвуулан ашиглах, шүүхийн хараат бус байдлыг хамгаалах бус түүнд халдах, хариуцлагагүй байдлыг дэвэргэх эрсдэлийг өсгөдөг. Иймээс шүүхийн захиргааны бүх чиг үүргийг нэг шүүхийн зөвлөлд төвлөрүүлэхийн оронд өөр өөр байгууллагад хуваарилах нь шүүгч хараат бус хийгээд хариуцлагатай, ил тод байх баталгаа болно.

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

Манай улсын шүүхийн захиргааны загварыг гадаад орнуудынхтай харьцуулан шинжилж, Шүүхийн захиргааны тухай хуулийн зарим заалтын хэрэгжилтийг судалсны үр дүнд Шүүхийн захиргааны загварыг цаашид боловсронгуй болгох асуудлаар дараах Зөвлөмж, дүгнэлтийг гаргалаа.

1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, бүтэц

2012 оны Шүүхийн захиргааны тухай хуулиар (ШЗТХ) ШЕЗ-ийн бүрэлдэхүүнийг орон тооны гишүүдээс бүрдүүлэхээр болж бүх шатны шүүхийн шүүгчид төдийгүй Хуульчдын холбоо болон Хууль зүйн яамны төлөөллийг багтааснаараа чухал шинэчлэл болжээ. Гэвч ШЕЗ хэт цөөн гишүүнтэй (5) төдийгүй шүүгчид давамгайлсан бүрэлдэхүүнтэй болсон. Энэ нь шүүгчийн хариуцлага суларч шүүгчдийн явцуу ашиг сонирхолд шүүхийн захиргаа үйлчлэх магадлалыг өсгөнө. Нөгөө талаас шүүхийн зөвлөлд дэх шүүгчдийн нөлөөг хэт багасгавал шүүгч хараат болох эрсдэлтэй. Иймд ШЗТХ-д шүүгчийн хараат бус, хариуцлагатай байдлыг хамгаалахад тустай дараах өөрчлөлт оруулахыг зөвлөж байна:

- ШЕЗ-ийн төлөөлөл чадавхыг нэмэгдүүлэх, бие даасан байдлыг бэхжүүлэх, үйл ажиллагааг чанаржуулахын тулд ШЕЗ-ийн гишүүдийн тоог 10 болгох;
- ШЕЗ-ийн бүрэлдэхүүнийг анхан шатны шүүхийн зөвлөгөөнөөс гурван шүүгч, давж заалдах шатны шүүхийн зөвлөгөөнөөс нэг шүүгч, хяналтын шатны шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг шүүгчийг сонгох, Хуульчдын холбооны Удирдах зөвлөл хоёр хуульчийг дийлэнх олонхын саналаар сонгох, Хууль зүйн сайдаас хууль зүйн сургуулийн үндсэн багшийг томилох замаар бүрдүүлэх;
- ШЕЗ-ийн гишүүнийг сонгохдоо чөлөөтэй, шууд, тэгш байх зарчмыг баримталж, шүүгчдийн зөвлөгөөн болон Хуульчдын холбооноос нууцаар санал хураах;

- ШЕЗ-ийн гишүүдийг Ерөнхийлөгч томилдогийг болиулах;
- ШЕЗ-ийн ажлын залгамж чанарыг хадгалах, шүүхийн захиргааны бодлогыг тогтвортой хэрэгжүүлэхийн тулд гишүүдийн гуравны нэгийг жил бүр сөөлжүүлэн шинээр томилох;
- ШЕЗ-ийн гишүүний ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэх, зөрчсөн эсэх маргааныг Шүүхийн ёс зүйн хороонд харьяалуулах;
- Шүүхийн захиргааны чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай асуудлаар зөвлөх хороо байгуулах бүрэн эрхийг ШЕЗ-д өгөх. Жишээлбэл, шүүгчийн ёс зүйн зөвлөмж өгөх хороо, шүүгчийн гүйцэтгэлийг үнэлэх хороо зэргийг байгуулах боломжтой.

2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэг, бүрэн эрх

Шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш шүүхийн захиргааны олон асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулалгүй явж ирсэн. 2012 оны Шүүхийн тухай багц хуулийн хүрээнд шүүхийн талаарх бодлого тодорхойлох, шүүхийн менежменттэй холбоотой ШЕЗ-ийн чиг үүргийг тодорхой болгож, тодорхой бүрэн эрхийг өгсөн нь шүүх хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал алхам болсон. Гэвч шүүхийн захиргааны бараг бүх чиг үүрэг, бүрэн эрх ШЕЗ-д төвлөрсөн бөгөөд ийм хүчтэй шүүхийн зөвлөл олон жил ажиллавал шүүгчийн явцуу ашиг сонирхлыг хамгаалах, шүүгчийн хараат бус байдалд халдах, хариуцлагагүй байдлыг дэвэргэх эрсдэлтэйг бусад улсын туршлага харуулдаг. Тиймээс Шүүхийн тухай багц хуульд дараах өөрчлөлтийг хийх хэрэгтэй:

- Шүүгчийн шалгаруулах, шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх, шүүгчийг огцруулах, чөлөөлөхтэй холбоотой чиг үүргийг ШЕЗ-өөс салгаж бие даасан, хөндлөнгийн байгууллагууд (Шүүхийн мэргэшлийн хороо, Шүүхийн ёс зүйн хороо)-д бүрэн харьяалуулж, уг ажилд ШЕЗ оролцохыг хориглох;
- Шүүхтэй холбоотой бодлого боловсруулах, тодорхойлох, шүүхийн менежментийг хэрэгжүүлэх, шүүхийн төсвийг боловсруулах чиг үүргийг ШЕЗ-д үлдээх;
- Шүүхийн захиргааны чиг үүргийг ШЕЗ, Шүүхийн мэргэжлийн хороо, Шүүхийн ёс зүйн хороо хэрэгжүүлэхэд Ерөнхийлөгчийн зүгээс оролцдогийг болиулах;
- Шүүхийн өөрчлөн байгуулалттай холбоотой 13 шүүгчийг буцаан томилоогүй, зарим шүүгчдээс саналыг нь асуулгүйгээр өөр шүүх рүү шилжүүлсэн асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль дахь шүүгчийн хараат бус байдлын зарчимд нийцүүлэн шийдвэрлэх, энэ тохиолдлоос үүдэн эрх зүйт ёс төлөвшсөн орнууд дахь шүүгчийг

огцруулах, чөлөөлөх үндэслэл, журмыг судалж Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг боловсронгуй болгох.

3. Шүүхийн төсөв

2012 онд Шүүхийн тухай багц хууль батлагдсанаар шүүгчийн эдийн засгийн хараат бус байдлыг бэхжүүлэх чухал алхмууд хийгджээ. Тухайлбал, ШЕЗ бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн УИХ-д шууд өргөн мэдүүлэх тухай заасан нь шүүхийн төсвийг нэмэгдүүлэхэд илүү дөхөмтэй болсон. Гэвч УИХ-аас шүүхийн төсвийг хангалттай хэмжээнд батлахгүй, төсвийг нь танаж ирсэн учраас шүүх хэвийн ажиллах нөхцөл бүрдэхгүй байна. Шүүхийн төсөвтэй холбоотой дараах тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй.

- ШЗТХ-ийн 6.1.1-д буй шүүхийн төсвийг УИХ-д шууд өргөн мэдүүлэх ШЕЗ-ийн бүрэн эрх нь Төсвийн тухай хуулийн 32.2, Засгийн газрын тухай хуулийн 8.2 гэсэн заалтуудтай зөрчилдөж хангалттай хэрэгжихгүй байгаа нь шүүхийн бие даасан байдалд сөргөөр нөлөөлж байгаа тул Үндсэн хуулийн 38-р зүйлийн 2-той нийцүүлэх;
- Шүүхийн дэд бүтцийн асуудал, тэр дундаа шүүхийн байрны дутагдал нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын өмнө шийдлээ хүлээсээр байгаа тул УИХ шүүхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг баталж, шүүх хэвийн ажиллах нөхцөлийг хангасан байртай болгох;
- 2016 онд шүүхийн төсөв, шүүгчийн цалинг бууруулах талаар хэлэлцсэн нь шүүгчийн хараат бус байдлын баталгааг үгүйсгэж Шүүхийн тухай хуулийн заалтыг зөрчсөн үйлдэл бөгөөд цаашид УИХ-аас шүүхийн төсвийг батлахдаа шүүхийн төсвийг өмнөх оны хэмжээнээс бууруулахгүй байх заалтыг чанд мөрдөх.

4. Шүүгчийн шалгаруулалт

2012 оноос хойш шүүгчийн шалгаруулалт зарим талаар сайжирч шүүгчдийн тоог 60 хувиар нэмж, шүүгч нарын ачааллыг бууруулсан нь шүүхийн шийдвэрийн чанар, хүртээмж сайжирахад нөлөөлсөн. Түүнчлэн шүүгчийн шалгалтыг илүү ил тод болгох, харьцангуй бодитой үнэлэхэд чиглэсэн зарим алхам хийгдсэн ч шүүгчийн сонгон шалгаруулалт шүүмжлэл дагуулсаар байна. Шүүгчийн шалгаруулалтад тулгарч буй асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах зохицуулалтыг журамлах хэрэгтэй:

- Шүүхийн мэргэшлийн хорооны шалгалтын дүнгээр хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг ШЕЗ Ерөнхийлөгчид засваргүйгээр өргөн мэдүүлдэг болох;
- ШЕЗ Шүүхийн мэргэшлийн хороог байгуулах,

гишүүдийг нь томилох, шүүгчийг шалгаруулахтай холбоотой дүрэм, журмыг боловсруулж батлахаас гадуур шүүгчийн сонгон шалгаруулалттай холбоотой чиг үүрэг хүлээхгүй байх;

- Шүүхийн мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд тавигдах шаардлагыг тодорхой болгох, бүрэн эрхийн хугацааг гурван жил болгон сөөлжин томилох, түүний гишүүний ёс зүйн дүрмийг боловсронгуй болгох;
- Шүүгчид нэр дэвшигчийн талаарх Монголын Хуульчдын холбооны дүгнэлтийг бодитой болгохын тулд нэр дэвшигчийг үнэлэх шалгуурыг зөв тогтоох, энэхүү зорилгоор байгуулагдсан хороогоор уг дүгнэлтийг гаргуулдаг болох.

5. Шүүгчийн гүйцэтгэлийн үнэлгээ

Шүүгчийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг тухайн шүүгчийг шагнах, эсхүл шийтгэхэд шууд ашиглах нь шүүгчийн хараат бус байдалд халдах эрсдэлийг үүсгэдэг учраас эдгээр үр дагавартай холбоотой заалтыг Үндсэн Хуулийн цэцээс хүчингүй болгосон нь зөв байсан. Гэвч Цэцээс шүүгчийн гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоог хэрэгжүүлж эхлэхээс өмнө бүхэлд нь хүчингүй болгосон нь ухралт болсон. Иймд шүүгчийн гүйцэтгэлийн үнэлгээг дахин хуульчлах тухай дараах зөвлөмжийг өгч байна:

- Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны үнэлгээг шүүгчийн гүйцэтгэлийн үнэлгээ гэж нэрлэх;
- Шүүгчийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, шүүгчийн зан төлөв, ёс зүйн төлөвшлийг сайжруулах замаар шүүгчийн ажлын гүйцэтгэлийг дээшлүүлэх зорилготойгоор шүүгчийн гүйцэтгэлийн үнэлгээг дахин хуульчлах;
- Шүүгчийн гүйцэтгэлийн үнэлгээнээс гарсан дүгнэлтийг тухайн шүүгч эсэргүүцэж байгаа бол дүгнэлтийг шүүхэд давж заалдах боломж олгох.

6. Шүүгчийн сахилга

Шүүгчийн ёс зүйн хорооны ажиллаж буй одоогийн эрх зүйн байдлыг хараат бусаар ажиллах, хариуцлага тооцох чадвартай байх, төвийг сахих гэсэн гурван үндсэн шалгуураар шалгаж үзэхэд төдийлөн сайн дүр зураг харагдахгүй байна. Тиймээс дараах зөвлөмжийг гаргаж байна:

- Шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх, шүүгчийг огцруулах, чөлөөлөх асуудлыг Шүүхийн ёс зүйн хороонд дангаар нь харьяалуулж

шийдвэрлүүлэх, уг ажиллагаан дахь ШЕЗ-ийн оролцоог халах;

- Шүүгчийн ёс зүйн дүрмийн агуулгыг олон улсын стандартын дагуу шинэчлэх, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмээс шүүгчид холбогдох заалтуудыг нэмж тусгах;
- Шүүгчийн мэргэжлийн алдаа болон ёс зүйн зөрчлийн ялгаа, давхцлыг оновчтой тодорхойлж хэвших;
- Шүүгчийн ёс зүйн гомдолд сахилгын хэрэг үүсгэх эсэхийг Шүүхийн ёс зүйн хорооны гурван гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар шийдвэрлэж байгаа нь хорооны орон тооны бус гишүүдийн ажлын ачааллыг механикаар нэмэгдүүлж байгаа тул сахилгын хэрэг үүсгэх эсэхийг нэг гишүүн шийдвэрлэх бөгөөд хэрэг үүсгээгүй тохиолдолд давж заалдах гомдол гаргах эрхийг эдлүүлэх;
- Шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэхэд шаардлагатай мөрдөн шалгах бүрэн эрх (шаардлагатай оролцогчийг дуудан ирүүлэх, нотлох баримт гаргуулж авах, цуглуулах, хууль сануулж мэдүүлэг авах зэрэг)-ийг Шүүхийн ёс зүйн хороонд өгөх;
- Шүүгчийн ёс зүйн зөрчлийг мөрдөн шалгах, нотлох, шийдвэрлэх чиг үүргүүдийг салгах (мөрдөн шалгах, нотлох чиг үүргийг бие даасан мөрдөгч, хуульчид харин хэргийг шийдвэрлэх чиг үүргийг Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнд тус тус хариуцуулах), шүүгчийн ёс зүйн зөрчлийг мөрдөн шалгах, нотлох чиг үүрэгтэй этгээд тухайн хэргийг шийдвэрлэх бүрэлдэхүүнд оролцохгүй байх;
- Шүүгчийн ёс зүйн дүрмийн 5.1-р зүйлийн 3-т “Зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл оногдуулж болохгүй” (мөн, Шүүхийн ёс зүйн хорооны дүрэмд 1 жил) гэж зааснаас үүдэн зарим шүүгч ноцтой ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон ч ямар ч хариуцлага хүлээхгүй өнгөрч, шүүгчид итгэх олон нийтийн итгэлийг унагааж байгаа тул сахилгын шийтгэл хүлээлгэх хөөн хэлэлцэх хугацааг сунгаж доод тал нь 3 жил болгох, мөн зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл Шүүхийн ёс зүйн хороонд ирсэн үеэс уг хугацааг тоолохыг зогсоодог болох.

1 Энэ нь Атеман, Елена нарын боловсруулсан хүснэгт боловч энэ судалгааны хүрээнд шүүхийн бие даасан байдал гэсэн баганыг уг хүснэгтэд нэмж, энэ хоёр үзүүлэлтээр улсуудыг эрэмбэлэн өөрчилсөн бөгөөд Монгол Улсын ШЕЗ-ийг шинээр нэмсэн. Violaine Autheman and Sandra Elena, “Global Best Practices: Judicial Council (Lessons Learned from Europe and Latin America)” (IFES Rule of Law White Paper Series, 2004), 29, http://pdf.usaid.gov/pdf_docs/PBAAB591.pdf.

2 Klaus Schwab, The Global Competitiveness Report 2014-2015 (World Economic Forum, 2015), 411, http://www3.weforum.org/docs/WEF_GlobalCompetitivenessReport_2014-15.pdf.